



**ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2022 оны 11 сарын 28 өдөр

Дугаар А/118

Ховд

Тооллогын комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 67.5 дахь заалт, Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2, 28 дугаар зүйлийн 28.1.3 дахь заалт, Батлан хамгаалахын төрийн болон албаны нууцыг хамгаалах журам”-ын 2 дугаар бүлгийн 2.1.4, 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабт ашиглагдаж байгаа онц чухал-маш нууц, маш-нууц, нууц ном материал, данс бүртгэлийн 2022 оны бүтэн жилийн тооллогыг 12 дугаар сарын 01, 02-ны өдрүүдэд зохион байгуулж явуулсугай.

2. Тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга: Б.Ганхуяг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга, хурандаа)

Гишүүд: Д.Одгэрэл (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дайчилгааны офицер, дэд хурандаа)

Д.Тамир (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын Орон нутгийн хамгаалалт, сургалтын офицер, хошууч)

Б.Түмэнжаргал (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Бичиг хэргийн эрхлэгч)

3. Онц чухал-маш нууц, маш-нууц, нууц ном материал, данс бүртгэлийг нэг бүрчлэн хуудас бүрээр нь тоолж, дүнг 12 дугаар сарын 02-ны өдрийн дотор танилцуулан актыг Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штабт хүргүүлэхийг комиссын дарга (Б.Ганхуягт)-д үүрэг болгосугай.

ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Б. Баярсүх

8400 03 0910
Tush A/112 Ba